



**МОНОС ХҮНС ХУВЬЦААТ КОМПАНИ**

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар  
2023 оны 04-р сарын 30

## **Нэг. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ХУВЬ**

1.1. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” -ийг шинэчлэн батлаж, нээлттэй хувьцаат компани, даатгагч, банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөхийг зөвлөсний дагуу Монголын Хөрөнгийн Биржийн гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/58 тоот тушаалаар “Компанийн засаглалын кодекс”-ийг үнэлэх аргачлалыг батласан. Уг аргачлалын дагуу “Монос хүнс” ХК -ийн “Компанийн засаглалын кодекс” -ийн хэрэгжилтийн үнэлгээг ТУЗ-өөс хийн хүргүүлж байна.

### **1.2. Үнэлгээний асуулгын бүтэц:**

- 1 -р зарчим. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
- 2 -р зарчим. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
- 3 -р зарчим. Тайлагнал, мэдээллийн ил тод байдал
- 4 -р зарчим. Аудит, хяналтын тогтолцоо
- 5 -р зарчим. Эрсдэлийн удирдлага
- 6 -р зарчим. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
- 7 -р зарчим. Оролцогч талуудын эрх ашиг
- 8 -р зарчим. Компанийн соёл.
- 9 -р зарчим. Хувьцаа эзэмшигчдийн эрх

### **1.3. Үнэлгээний оноо, нэгдсэн үнэлгээ:**

Асуулга тус бүрийн хувьд доорх оноогоор үнэлж, үнэлгээг хувиар тооцож гаргасан.

- бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2,
- хэсэгчлэн хэрэгжүүлсэн, хугацаа заасан, авах арга хэмжээ, зорилгоо тайлбарласан 1,
- үнэлгээ өгөөгүй бол 0

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

- авбал зохих нийт онооны 90% - түүнээс дээш -- засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70% - 89% --дунд засаглалтай, цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50% -69% -- хангалтгүй засаглалтай, эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49% - түүнээс доош -- муу засаглалтай, үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

## Хоёр.ҮНЭЛГЭЭНИЙ БҮТЭЦ

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байх ба “Монос хүнс” ХК-ийн засаглалын үнэлгээний тайлан 2023 оны 4 дүгээр сард дараах үнэлгээтэй байсан байна. Үүнд:

№	Зарчим	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ГУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10		83.3%
2	ГУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	8		80%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	5		83.3%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		100%
5	Эрсдэлийн удирдлага	8	5		62.5%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4		66.6%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6		75%
8	Компанийн соёл	6	1		16.7%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100%
	<b>НЭГДСЭН ДҮН</b>	<b>72</b>	<b>55</b>		<b>76.4%</b>

Дээрх хүснэгтэд үнэлсэн дүнгээс харахад “Монос хүнс” ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 76.4% буюу дунд засаглалтай, цаашид эрсдэл үүсч болзошгүй тул анхаарч ажиллах гэсэн үр дүн гарсан байна. Иймд “Монос хүнс” ХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-т тусгасан засаглалын 9 зарчмын хүрээнд баримт бичгээ боловсруулан, процессоо тодорхойлж, засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагуудаас гаргасан журмын хэрэгжилтийг ханган, дээрх үнэлгээний тайланд дутуу, байхгүй гэж үнэлэгдсэн бүхий л шаардлагыг бүрэн ханган баримт бичиг, журам, тайлан, үйл ажиллагаа зэргээ сайжруулан ажиллах болно.

**Гурав. ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН  
/ МОНОС ХҮНС ХК/**

2023.04.30

Улаанбаатар хот

<b>Компанийн засаглалын үнэлгээний асуулга</b>					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i>					
<b>НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>					
<b>ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна</b>					
<b>№</b>	<b>Зүйл</b>	<b>Хэрэгжилт</b>	<b>Тайлбар</b>	<b>Оноо</b>	<b>Хувь</b>
1	<b>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам 2019-8-26 өдрийн 12/08 тоот ТУЗ тогтоолоор баталсан, 2021-05-17 өдрийн 06/05 ТУЗ тогтоолын хавсралтаар нэмэлт өөрчлөлт оруулсан. Журамд ТУЗ-ийн бүрэлдэхүүний чиг үүргийг нарийвчлан зохицуулсан. КЗК-ийн 1.1 зарчимд нийцүүлэн нэмэлт өөрчлөлтийг 2023-05-10 өдрийн ТУЗ хурлаар дахин хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Нэмэлт өөрчлөлт батлагдсан үед тогтоол батлагдсан журмыг хүргүүлэх болно. /Баримт бичгийн жагсаалт 1/ /Баримт бичгийн жагсаалт 2/ /Баримт бичгийн жагсаалт 3/	2	
2	<b>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтын КТХ, компанийн дүрмийн 7.17 заалтаар ТУЗ дэргэдэх ЦУНДХ-ы бүрэн эрхийг тодорхойлж, хорооноос ТУЗ гишүүнийг сонгон шалгаруулах, томилох эрх үүргийн заалтыг ТУЗ ҮАЖ-д тусгасан мөрдөж байна. 2023-05-10 өдрийн хурлаар ЦУНДХ-ы бие даасан журам, Залгамж халааны бодлогын баримт бичгийг хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөж байна. Уг журамд, ТУЗ гишүүний сонгон шалгаруулалт, томилгоо, чөлөөлөх, ирц, идэвх оролцоог үнэлэх, ТУЗ, ГЗ, удирдлагын багийн залгамж халааны зохицуулалтыг тусгахаар төлөвлөөд байна. /Баримт бичгийн жагсаалт 4/ /Баримт бичгийн жагсаалт 5/	1	
3	<b>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат</b>	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт	ТУЗ гишүүдийн хувьцааны эзэмшил, ажлын мэдээлэл, хараат бус байдлын мэдээллийг МХБ сайтад нээлттэй байршуулсан байгаа, компанийн улирал бүрийн тайлан дээр гишүүдийн	2	

	<i>бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i>	хийхээр төлөвлөж байна.	мэдээллийг тавьж байгаа. Компанийн вэб хуудас хөгжүүлэлт хийж байгаа бөгөөд цаашид хараат бус гишүүдийн тайлан, ТУЗ нийт гишүүдийн хурлын ирцийн мэдээлэл, хэлэлцсэн асуудалд хандсан байр суурийн талаар мэдээллийг нээлттэй тайлагнаж байхаар вэб хуудсын нэмэлт хөгжүүлэлтийг хийж байгаа болно. /Баримт бичгийн жагсаалт 6/		
4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.16, 7.17, 7.18 заалтууд, ТУЗ-ийн ҮАЖ-ийн 12 дугаар хэсэгт хороодын бүтэц зохицуулалт, журмын 3 дугаар зүйлд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд тавигдах боловсрол, туршлага зэрэг шаардлагыг тодорхойлж тусгасан. Компанийн ТУЗ, нийт ажилтны хувьд хүйсийн харилцаа харьцангуй тэнцвэрт байдлыг хадгалж байдаг бөгөөд ТУЗ-ийн 9 гишүүний 4 нь эрэгтэй, 5 нь эмэгтэй гишүүд юм. Цаашид компанийн зүгээс ТУЗ, ЭБАТ, ажилтны хүйсийн тэнцвэрт байдлыг хангах зохицуулалтыг тусган хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөж байна. /Баримт бичгийн жагсаалт 1/	2	
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	2022-04-23 өдөр ХЭЭХ-аас шинээр сонгогдсон ТУЗ гишүүдийг анх томилогдсоны дараа КТХ-ийн 76, ТУЗ хараат бус гишүүдэд 79-р заалт, компанийн дүрмийн 7, хороодын гишүүдэд тухайн хорооны үүргийг, мөн ТУЗ ҮАЖ зэргийг танилцуулж, чиглүүлэг өгдөг. ЦУНДХ-ы хорооны дүрэмд ТУЗ гишүүдэд мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж байх хугацааны болон бусад зохицуулалтыг тусган хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. / Баримт бичгийн жагсаалт 4/	1	
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.20-7.23 заалт, ТУЗ ҮАЖ-ын 13 дугаар зүйлд мөрдвөл зохих ёс зүйн хэмжээг тусгаж өгсөн. / Баримт бичгийн жагсаалт 3/	2	
ДҮН				10	83%

<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b> <b>ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор</b> <b>дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ</b>					
7	<b>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн 9 гишүүний 3 нь хараат бус гишүүн, хараат бус гишүүдийг олон нийтэд нээлттэйгээр зарлаж, ХЭХ-аар хэлэлцүүлж сонгосон, мөн ердийн 1 гишүүн нь жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн 4 нь нэгдмэл сонирхолтой бус гишүүд юм. ТУЗ-ийн хурлаас гаргах шийдвэр гаргалтыг хараат бус гишүүдийн санал, шийдвэрт голлох зорилгоор ТУЗХ-аар хэлэлцэх асуудлыг ТУЗ-ийн дэргэдэх хороодоор эхлэн хэлэлцүүлдэг учир хороодын гишүүдийн дийлэнх хувийг хараат бус гишүүдээс бүрдүүлж, 3 хорооны даргыг хараат бус гишүүдээс сонгон удирдуулж байна. Үүнд: АХ-ы даргаар хараат бус гишүүн О.Лхагвасүрэн, НДЦУХ-ы даргаар хараат бус гишүүн Б.Гантулга, СБХХ-ы даргаар хараат бус гишүүн Ш.Алтанбагана нарыг сонгосон. Цаашид гишүүдийн дийлэнх хувийг хараат бус болгох, ТУЗ-ийн даргыг хараат бус гишүүнээр томилоход зорин ажиллана. / Баримт бичгийн жагсаалт 7/	2	
8	<b>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь дэргэдээ гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих зорилгоор дотоод аудиторыг ажиллуулдаг бөгөөд бие даасан “Дотоод аудитын дүрэм”, дотоод аудитын жилийн төлөвлөгөөг гарган батлаж ажилладаг. Хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Лхагвасүрэн ажилладаг. Тус хороо нь сардаа 1 удаа хуралдаж, бие даасан байдлаар гүйцэтгэх удирдлага, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналтаа тавьж ажиллаж байна. / Баримт бичгийн жагсаалт 8/ / Баримт бичгийн жагсаалт 9/	2	
9	<b>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Компанийн дүрмийн 7.17 хэсэгт тусгасан. Монос хүнс ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх ЦУНДХ нь хамт байдаг бүтэцтэй. Хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Гантулга томилогдсон, хорооны бус ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирал хуралд хүсэлтээр оролцдог. Хорооны гишүүдийн дийлэнх хувь нь хараат бус гишүүдээс бүрддэг	1	

	<i>урамишууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамишууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>		ЦУНДХ нь одоогоор бие даасан журамгүй байгаа, шинээр батлагдсан КЗК-ийн үндэслэн журмын төслийг шинэчлэн боловсруулж байна. Залгамж халааны бодлогын баримт бичгийг хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөж байна.  / Баримт бичгийн жагсаалт 4/ / Баримт бичгийн жагсаалт 5/ / Баримт бичгийн жагсаалт 9/		
10	<i>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.		1	
11	<i>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	ТУЗ нь дэргэдээ Аудитын хороо, Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооноос гадна Стратеги, бизнес хөгжлийн хороо гэсэн 5 гишүүнээс бүрдсэн хороотой, хорооны дарга нь ТУЗ хараат бус гишүүн Ш.Алтанбагана. Хороодын чиг үүргийг компанийн дүрэм болон ТУЗ ҮАЖ-д зааж өгсөн. Хороодын гишүүдийн дийлэнх хувь нь хараат бус гишүүдээс бүрддэг. / Баримт бичгийн жагсаалт 10/ / Баримт бичгийн жагсаалт 9/	2	
ДҮН				8	80%
<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b>					
12	<i>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	КТХ, ҮЦЗЗТХ болон эрх бүхий байгуулагуудаас гаргасан журамд заасан хугацаанд компанийн засаглалын болон үйл ажиллагаа, санхүүгийн мэдээллийг тогтмол нээлттэйгээр тайлагнадаг. МХБ сайт, компанийн вэб хуудас-т цахимаар санхүүгийн болон үйл ажиллагаа, засаглалын тайлан мэдээллийг байнга байршуулдаг. Биет хэлбэрээр зохицуулагч байгууллагад тайлант хугацаандаа хүргүүлж хянуулж	2	

			байна. Цаашид СЗХ-ы “Үнэт цаасны журам”-ын дагуу дээрх тайлан мэдээллийг хугацаанд нь тайлагнаж байх зохицуулалт бүхий “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ыг хэлэлцүүлэн батлуулахаар боловсруулаад байна. / Баримт бичгийн жагсаалт 11/		
13	<b>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Компанийн <a href="https://www.monosfoods.mn/">https://www.monosfoods.mn/</a> вэб хуудсын “Мэдээ мэдээлэл” талбарт тухай бүрд мэдээлж байсан. Цаашид “Хувьцаа эзэмшигчдэд” талбарыг шинээр нэмж үүсгэн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад чиглэсэн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, засаглалын баримт бичиг, дүрэм журам, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, ТУЗ тогтоол, зар мэдээ зэргийг байршуулах талбар болгон тогтмол мэдээллийг шинэчлэн байршуулж байхаар хөгжүүлэлтийг хийж байна. / Баримт бичгийн жагсаалт 12/	1	
14	<b>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Санхүүгийн тайланг хуульд заасан хэлбэрээр хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарт ойлгомжтой хувилбараар тогтмол тайлагнаж, жил, улирлын төлөвлөгөөг гүйцэтгэл, эерэг, сөрөг дүгнэлтийн хамт ТУЗ-д хэлэлцүүлж баталгаажуулсан тайланг олон нийтэд тогтмол хугацаанд нь тайлагнадаг. Монос хүнс ХК нь компанийн үйл ажиллагаанаас үүсэж буй байгаль орчин, нийгэм засаглал (БОНЗ/ESG)-ын нарийвчилсан суурь үнэлгээ хийх, БОНЗ-ын тайлагналын стандартыг нэвтрүүлэх зорилгоор ЕСБХБ /EBRD/-ны санхүүжилтээр “Ризилиенс Консалтинг Сервиз” ХХК-аас МУ-ын 4 компанид 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хийсэн үнэлгээнд хамрагдаж, үнэлгээний тайлангаа авсан. Үнэлгээ хийсэн компани нь үнэлгээндээ НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ), ОУ-ын санхүүжүүлэгч байгууллагуудын түгээмэл мөрддөг БОНЗ-ын шаардлагууд болох ОУ-ын санхүүгийн корпорацийн (ОУСК): Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт, Европын холбооны Тогтвортой байдлын тайлагналын стандарт конвенц, тунхаглал болон Монгол улсын холбогдох хууль, стандарт, журамд заасан шаардлагуудыг үндэслэн суурь үнэлгээг нийт 225 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж үзэхэд 153 шалгуур бүрэн	2	



			биелсэн, 24 шалгуур бүрэн бус, 48 шалгуур биелээгүй буюу компанийн БОНЗ үнэлгээ 68% биелэлттэй гэж дүгнэсэн тайланг 2023-04-25 өдөр ирүүлээд байна. Тайлангийн хураангуйг компанийн вэб хуудаст тавьж тайлагнахаар бэлтгэж байна. Цаашид тайлангийн агуулгаа тасралтгүй сайжруулан ажиллах болно. / Баримт бичгийн жагсаалт 13/		
<b>ДҮН</b>				5	83%
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>					
<b>ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана</b>					
15	<b>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Компанийн дүрмийн 7.16 заалтад Аудитын хорооны эрх үүргийг тусгахдаа хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, хийх ажилд нь чиглэл өгөх, гэрээний нөхцлийг тодорхойлох эрх үүргийг тусгаж өгсөн. АХ нь жил бүр хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, жилийн эцсийн тайланд аудит хийх үед чиглүүлэн, хамтарч ажиллах, хийсэн дүгнэлтийг хянах, жилийн эцсийн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр тайлагнах, ТУЗ-д танилцуулах зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэдэг. Аудитын хорооны бие даасан журмын төслийг боловсруулж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлахаар бэлтгэж байна. / Баримт бичгийн жагсаалт 8/ / Баримт бичгийн жагсаалт 14/	2	
16	<b>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	2019 онд Монос хүнс ХК хэлбэрээ өөрчлөн нээлттэй хувьцаат компани болсноос хойш жил бүр КТХ-д заасан хугацаанд ХЭЭХ-аа хуралдуулж хуралдаа хөндлөнгийн аудит хийсэн БДО аудит ХХК-ийн гүйцэтгэх удирдлага, хяналт шалгалт хийсэн аудиторыг урин оролцуулж тайланг өөрсдөөр нь тавиулж дадсан. / Баримт бичгийн жагсаалт 15/	2	
17	<b>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн дэргэдэх АХ-ы дэргэд дотоод аудитор ажилладаг бөгөөд төлөвлөгөөт болон гэнэтийн хяналт шалгалтыг АХ-ы гишүүд даргын удирдлага доор сар бүр гүйцэтгэх удирдлага, компанийн үйл ажиллагаанд хийж, эргэн Аудитын хороонд тайлагнаж ажиллаж байна. Цаашид энэ мэдээллийг компанийн вэб хуудаст нээлттэйгээр олон нийтэд тайлагнаж ажиллахыг зорих болно. / Баримт бичгийн жагсаалт 16/	2	

	цахим олон тухай мэдээлнэ.	хуудсаар нийтэд бүр			
ДҮН			6	100%	
<b>ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>					
<b>ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина</b>					
18	<b>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн дэргэдэх Стратеги, бизнес хөгжлийн хороо болон Аудитын хорооны чиг үүрэгт эрсдэлийн удирдлагыг багтаан өгсөн. Компанид Гүйцэтгэх захирлын удирдлага дор ажилладаг эрсдэлийн удирдлагын багтай, баг нь үйл ажиллагаагаа ГЗ-аар дамжуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодод тайлагнадаг. Компани жилд 2 удаа “Retreat” арга хэмжээг дотооддоо зохион байгуулж, уг арга хэмжээгээр дотоод, гадаад хүчин зүйлд үндэслэн учирч болох эрсдэл, учруулж болох сөрөг нөлөөг тодорхойлох, үнэлэх үйл ажиллагааг хийдэг. Ийнхүү болзошгүй эрсдэлээ тодорхойлж, үнэлснээр эрсдэлээс зайлсхийх, эрсдэл учирах үед авах хариу арга хэмжээг тодорхойлж ажиллаж байна. Компани үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг “Эрсдэлийн удирдлагын журам”-аар зохицуулдаг. Уг журамд ТУЗ, түүний дэргэдэх хороодын хяналт тавих зохицуулалтыг нэмж тусган сайжруулалтыг хийж батлах / Баримт бичгийн жагсаалт 17/	2	
19	<b>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж,</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	ТУЗ нь бие даасан эрсдэлийн удирдлагын хороо гэсэн нэртэй хороо байхгүй, стратеги бизнес хөгжлийн хороо, аудитын хороондоо энэ чиг үүргийг хавсардаг. Стратеги бизнес хөгжлийн хороо хуралдах үедээ компанийн эрсдэлийн удирдлагын багийн тайлантай танилцаж, компанийн хэмжээнд учирч болох эрсдэл, хариу арга хэмжээний талаар хэлэлцэж зөвлөмж өгч, чиглүүлэн, хяналт тавьж ажилладаг. Хорооны үйл ажиллагааны журамд зохицуулалтыг тусгаж өгөх, / Баримт бичгийн жагсаалт 10/	1	

	<i>тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>				
20	<b>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Компанийн улирлын болон хагас жил, жилийн эцсийн тайланд нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхэд багачууд, нийгмийн эмзэг бүлэг, ахмад настанд хандан хийсэн ажлуудыг тусган тайлагнаж байгаа. Мөн компанийн онцлог болсон ард түмний эрүүл мэнд, өвчлөлийн эсрэг өөрсдийн эрүүл мэндийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн нийтэд хүргэн ажиллаж байна. Байгаль орчинд аюулгүй, ээлтэй байх үүднээс үйлдвэртээ хэмнэлттэй цахилгааны хэрэглээг ашиглах, саарал ус ашиглаж үйлдвэрийн ахуйн усаа шийдвэрлэх, хог хаягдлаа ангилан ялгаж, дахивар хог хаягдлаа тушаах зэргээр ажиллаж байна. / Баримт бичгийн жагсаалт 12/	1	
21	<b>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	ТУЗ нь компанийн комплайнсын хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны удирдлага доор ажилладаг дотоод аудиторын үйл ажиллагаагаар дамжуулан хяналтаа тавин ажиллаж байна. Цаашид комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор комплайнсын ажилтан, нэгжийн орон тоог үүсгэж компанийн бүтэц орон тоонд өөрчлөлт оруулахаар хэлэлцүүлж ажиллах болно.	1	
<b>ДҮН</b>				5	63%
<b>ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b> Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	<b>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ирэх оны ТУЗ-ийн төсвийг батлуулахдаа хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-ийн гишүүдийн өнгөрсөн онд олгосон цалин урамшуулалыг тайлагнаж, төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар батлан шийдвэрлэдэг. ТУЗ-ийн цалинг улиралд 1 удаа, ээлжит болон ээлжит бус хурлын оролцоогоор олгодог. ТУЗ төсвийг батлагдсан тогтоолын хамт МХБ-ийн нээлттэй сайтад байршуулдаг	2	
23	<b>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Энэ мэдээллийг нээлттэйгээр тайлагнадаг, мөн компанийн дүрмийн 7.17, ТУЗ ҮАЖ-ийн 9 дүгээр зүйлд тодорхой тусгасан. ЦУНДХ-оор компанийн эрх бүхий албан тушаалтнуудын цалин	1	

	<i>бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</i>		урамшууллын хэмжээг тогтоох, үндэслэл, шалгуурыг тусгасан “Цалин урамшууллын бодлого” -ыг 2023 оны 2 дугаар улирлын ТУЗ хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна. / Баримт бичгийн жагсаалт 1/		
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Ирэх жилийн төсөвт болон жилийн эцсийн тайланд тусгайлан тусгадаг, мөн сар бүр цалин, урамшууллыг компанийн төлөвлөгөөний гүйцэтгэлтэй уялдуулан ТУЗ-ийн даргаар батлуулж байна. Гүйцэтгэх захирлын ажлыг жил бүр компанийн үйл ажиллагаа, ашгийн үзүүлэлттэй уялдуулан дүгнэж гэрээг сунгах эсэх шийдвэрийг ТУЗ-аас гарган, гэрээг шинэчлэн байгуулж байна. 6.2-д тусгасан бодлогод зохицуулалтыг тусган батлуулна.	1	
<b>ДҮН</b>				4	67%
<b>ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b>					
<b>Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ</b>					
25	<i>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Компанийн тогтвортой өсөлтийг хангах, дунд болон урт хугацаанд үнэ цэнийг бий болгоход гол нөлөө бүхий оролцогч талууд болох 9000 гаруй хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, 250 орчим ажилтан, 200 гаруй бэлтгэн нийлүүлэгч, 8000 гаруй харилцагчидтай хамтран ажиллах явцад тэдний эрх ашгийг хангах талд анхааран ажиллаж, тэдний ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж ажиллахад зорин ажиллаж байна. Компани энэ харилцааг зохицуулсан “Санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам” -ыг мөрдөн ажилладаг бөгөөд цаашид ТУЗ-өөс оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг болоовсруулахаар төлөвлөж байна. / Баримт бичгийн жагсаалт 18/	1	
26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Компани анх нээлттэй хувьцаат компани болохдоо олон нийтэд танилцуулж байсан проспектуст тулгуурлан компанийн үндсэн богино болон урт хугацааны стратегийг баримтлан оролцогч талуудыг мэдээллээр хангах, хамтран ажиллах боломжит хувилбарыг сонгон ажиллаж байна.	1	

	<i>баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>				
27	<b>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Компанийн зүгээс хийж буй ажлыг цаг алдахгүй мэдээлэх, үүгээр оролцогч талуудыг мэдээллээр тогтмол хангахад чиглэн ажилладаг. Мөн компанийн хувьцаа эзэмшигчдийн фэйсбүүк группыг үүсгэн тогтмол мэдээлэл пост оруулах, шинэ болон сав баглаа өөрчлөгдсөн бүтээгдэхүүний мэдээллээр хангах, санхүү тайлан, засаглалын үйл ажиллагаатай танилцах, үйлдвэрийн процесс, компанийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, хувьцааны ханшийн өөрчлөлт зэрэг мэдээллийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран оруулж, шууд дамжуулалт хийх, видео бичлэг үзэх боломжоор ханган мэдээллэж, комментоор сэтгэгдлийг хүлээн авч хариулах зэргээр сошиал орчинг харилцааны бас нэгэн хурдацтай талбар болгон ашиглаж байна. / Баримт бичгийн жагсаалт 19/	2	
28	<b>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Компани “Хөдөлмөрийн дотоод журам”, “Олон нийттэй харилцах журам”, “Санал гомдол хүлээн авах журам” зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журмаар ажилчид, хэрэглэгчид, ханган нийлүүлэгчид, эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хэвлэл мэдээлэл, төрийн болон төрийн бус бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж байна. / Баримт бичгийн жагсаалт 18/ / Баримт бичгийн жагсаалт 20/	2	
<b>ДҮН</b>				6	75%
<b>НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ</b>					
<b>ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</b>					
29	<b>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 13 дахь хэсэгт ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын баримталбал зохих ёс зүйн хэм хэмжээг тодорхойлж өгсөн. Цаашид ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнууд, нийт ажилтнуудын мөрдвөл зохих ёс зүйн зарчим болон ёс зүйн хэм хэмжээг нарийвчлан заасан бие даасан “Ёс зүйн дүрэм”-ийг боловсруулан гаргаж ТУЗ-ийн хурлаас батлуулан, журмын мэдээллийг түгээх, хэрэгжилтийг хангуулахаар гүйцэтгэх захиралд үүрэг чиглэл өгөн ажиллахаар төлөвлөж байна. / Баримт бичгийн жагсаалт 1/	1	

30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Хэрэгжүүлэх	8.1-д тусгасан “Ёс дүйн дүрэм”-д заасан хэм хэмжээг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд хариуцлага тооцох, зөрчлийг мэдээлэх, мэдээлэл өгсөн ажилтны нууцлалыг хангах, ажлын байр бусад нөхцлийг хамгаалах зохицуулалтийг тусган, “шүгэл үлээгчийн” тогтолцоог бүрдүүлэн журамлахаар төлөвлөж байна.	0	
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Хэрэгжүүлэх	“Ёс зүйн дүрэм”-д ашиг сонирхлын зөрчил, авлига, хээл хахуулиас ангид хуулийн хүрээнд ажиллах зохицуулалтыг тусгаж өгөх, ТУЗ нь “Ёс зүйн дүрэм”-д нийцүүлэн авлига албан тушаалын зөрчлөөс сэргийлэх, хандив, бэлэг дурсгал өгөх, авах зохицуулалтыг тусгасан “Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ийг боловсруулан батлаж, компанид мөрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэх удирдлагад даалгаж ажиллахаар төлөвлөж байна.	0	
<b>ДҮН</b>				1	17%
<b>ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>					
<b>Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана</b>					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Монос хүнс ХК-ийн вэб хуудаст Хувьцаа эзэмшигчдэд талбарт хувьцаа эзэмшигчдэд тусгайлан шаардлагатай мэдээллийн талбарыг үүсгэсэн. Энэ талбар нь дотроо <ul style="list-style-type: none"> <li>• Хувьцааны тухай</li> <li>• Компанийн тухай</li> <li>• Санхүүгийн мэдээлэл</li> <li>• Үйл ажиллагааны тайлан</li> <li>• Төлөөлөн удирдах зөвлөл</li> <li>• Хувьцаа эзэмшигчдийн хурал гэсэн дэд талбаруудтай. Талбар бүрт мэдээллийг шинэчлэн оруулан мэдээлж тайлагнадаг.</li> </ul> / Баримт бичгийн жагсаалт 19/ Мөн Монголын хөрөнгийн биржийн вэб хуудаст мэдээллийг тухай бүрд шинэчлэн байршуулж байна.	2	
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Монос хүнс ХК нь хувьцаа эзэмшигчиддээ мэдээллийг шуурхай түгээх үүднээс компанийн вэб хуудас <a href="https://www.monosfoods.mn/investor">https://www.monosfoods.mn/investor</a> , фэйсбүүк групп- <a href="https://www.facebook.com/MonosFoods/">https://www.facebook.com/MonosFoods/</a> , Монос хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн фэйсбүүк групп <a href="https://www.facebook.com/groups/1030367210486131/">https://www.facebook.com/groups/1030367210486131/</a> зэрэг цахим талбаруудыг тогтмол ашиглан мэдээлэл, сургалт, мэдлэг, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, зар, шинэ	2	

			<p>бүтээгдэхүүний танилцуулга зэргийг тогтмол хүргэж байна.</p> <p>Мөн хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр төлөвлөгөөний хүрээнд “Голомт капитал”, “Таван богд капитал” БДК-уудтай урт хугацааны хамтран ажиллах гэрээг байгуулж, хөрөнгө оруулагчдад урт хугацааны хувьцааны хөрөнгө оруулалт хийхийн ашиг тус, хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох сургалт мэдээлэл, Монос хүнс ХК-ийн хувьцааны мэдээлэл, компанийн ашигт ажиллагааны талаар тогтмол мэдээлж, цахим мэдээллийг түгээн хамтран ажиллаж байна.</p>		
34	<p><b>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</b></p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.</p>	<p>Цар тахлын үед /2020, 2021 онуудад/ цахимаар ХЭЭХ-д оролцох бололцоог нээж цахимаар хурлыг шууд дамжуулалтын багтай хамтран зохион байгуулсан, 2022 оны 4 сарын 23 өдөр нийт 26000 хувьцаа эзэмшигчтэй Монголын ТОП 5 ХК (Мандал даатгал ХК, Мандал ирээдүйн өсөлт ХОС, Түмэн шувуут ХК, Цэнтрал экспресс ХК, Монос хүнс ХК) компаниудтай хамтран Хөрөнгө Оруулалтын Экспо-г амжилттай зохион байгуулж, ХЭЭХ-д 6500 хувьцаа эзэмшигчдээс 215 хувьцаа эзэмшигч танхимд хүрэлцэн ирж хуралд оролцсон. 2023 оны 4 сарын 29-ний хурлыг зайнаас болон танхим хосолсон байдлаар зохион байгуулахаар төлөвлөж ажиллаж байна. Хурлын зарыг боломжит бүх сувгаар, мэйлээр, утсаар түгээж хуралд оролцох боломжоор хангасан.</p>	2	
35	<p><b>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</b></p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.</p>	<p>КТХ-д заасан ХЭ-ийн бүрэн эрхийн хэмжээнд шийдвэрлэх асуудлыг хууль болон зохицуулагч байгууллагаас гаргасан журмын хүрээнд хэлэлцэх асуудалд тусган ХЭЭХ-д оролцсон ХЭ-ийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэх боломжтой.</p>	2	
36	<p><b>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</b></p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.</p>	<p>Сонирхлын зөрчилтэй хэлцэл болон нэгдмэл сонирхолтой хэлцлийг Компанийн тухай хуульд зааснаар зохицуулдаг. Компанийн дүрмийн 7.16.4-д зааснаар Аудитын хороо хяналтаа тавьж, тухайн хэлцэлд сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхийн шийдвэрээр асуудлыг шийдвэрлэж байна. 2022 онд сонихлын зөрчилтэй хэлцэл 1 хийгдсэн. Компани тухайн жилд хийсэн СЗХ болон ИХХ-ийн мэдээлэл, шийдвэр гаргалтыг хөндлөнгийн аудитын байгууллагад</p>	2	

		хянуулж хөндлөнгийн аудитын төлөөллөөр ХЭЭХ дээр тайлагнадаг.		
<b>ДҮН</b>			10	100%
<b>НЭГДСЭН ДҮН</b>			55	76.4%

**Баримт бичгийн жагсаалт:**

1. ББ1-ТУЗ-ийн үйл ажиллагааны журам /2019.08.26/
2. ББ2-ТУЗ-ийн үйл ажиллагааны журам /2021.05.17/
3. ББ3-ТУЗ-ийн болон ТУЗ НБД -ын 2022 оны тайлан
4. ББ4-ЦУНДХ-ы үйл ажиллагааны журам
5. ББ5-Залгамж халааны бодлого
6. ББ6-Компанийн цахим хуудаст байршуулсан ТУЗ гишүүдийн мэдээлэл
7. ББ7- ТУЗ-ийн дэргэдэх хороодын 2022 оны тайлан
8. ББ8- Аудитын хорооны үйл ажиллагааны журам
9. ББ9-ТУЗ хороодын дарга, гишүүдийг томилсон тогтоол /2022.05.05/
10. ББ10-СБХХ-ы үйл ажиллагааны журам
11. ББ11- Компанийн цахим хуудаст байршуулсан жилийн эцсийн тайлангууд
12. ББ12- Компанийн цахим хуудаст байршуулсан мэдээ мэдээллийн булан
13. ББ13- БОНЗ /ESG/ суурь үнэлгээний тайлан
14. ББ14- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох ТУЗ тогтоол /2022.11.10/
15. ББ15- Хувьцаа эзэмшигчдийн хурлын бичлэг /2023.04.29/
16. ББ16-Дотоод аудиторын дүрэм /2021.05.17/
17. ББ17-Эрсдэлийн удирдлагын журам
18. ББ18- Санал гомдол хүлээн авах журам
19. ББ19- Компанийн цахим хуудас
20. ББ20- Олон нийттэй харилцах журам

-оОо-